



**ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМ, “МОНГОЛЫН
АРХИТЕКТОРУУДЛЫН ЭВЛЭЛ” ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ХООРОНД
ТӨРИЙН ЧИГ ҮҮРГИЙГ ГҮЙЦЭТГҮҮЛЭХЭЭР БАЙГУУЛСАН 2025/50 ДУГААР
ГЭРЭЭНИЙ 2025 ОНЫ ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМ, “МОНГОЛЫН
АРХИТЕКТУРУУДЫН ЭВЛЭЛ” ТББ-ЫН ХООРОНД ТӨРИЙН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ
ГҮЙЦЭТГҮҮЛЭХЭЭР БАЙГУУЛСАН 2020/50 ДУГААР ГЭРЭЭНИЙ 2025 ОНЫ
ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН
2026.01.08

НЭГ.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, АРГА ЗҮЙ

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам (цаашид ХББОСЯ гэх) төрийн зарим чиг үүргийг гүйцэтгүүлэхээр “Монголын Архитекторуудын Эвлэл” ТББ (цаашид МАЭ гэх)-тай 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдөр байгуулсан “Архитектор, хот төлөвлөлтийн мэргэжилтнийг давтан сургах, мэргэшил дээшлүүлэх сургалтын чиг үүргийг гүйцэтгүүлэх тухай” 2025/50 дугаар гэрээ, гэрээний дагуу ХББОСЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга (цаашид ТНБД гэх)-ын 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/99 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “МАЭ-ээс 2025 онд зохион байгуулах барилгын салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг горилох, сунгах сургалтын нэгдсэн төлөвлөгөө”-ний 2025 оны биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт өгч, удирдлагад танилцуулж цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж хүргүүлэх, удирдлагыг холбогдох мэдээллээр хангахад энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын ЗОРИЛГО оршино.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2025 оны “Журам батлах тухай” 43 дугаар тогтоолын 3-р хавсралтаар баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ыг үндэслэл болгон баримталж, тус журмын 3 дахь хэсгийг удирдлага болгоно.

ХОЁР.ТАНИЛЦУУЛГА

МАЭ нь Монгол Улсын мэргэжлийн ууган төрийн бус байгууллагуудын нэг бөгөөд 1956 онд БНМАУ-ын сайд нарын зөвлөлийн 545 дугаар тогтоолоор байгуулагджээ.

Монголын архитектурыг хөгжүүлэх, гишүүд архитекторуудын хууль ёсны эрх ашгийг хамгаалах, гишүүдээ дэмжих, мэргэшүүлэх, архитекторуудаа олон улсад хүлээн зөвшөөрүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, гишүүддээ болон нийтэд үйлчилдэг, 800 гаруй гишүүдтэй, аймаг, нийслэлд 10 салбар зөвлөлтэй мэргэжлийн төрийн бус байгууллага юм. (Эх сурвалж <https://uma.barilg.mn>)

Куба Улсын нийслэл Гаван хотод 1963 онд болсон Олон Улсын Архитекторуудын Эвлэлийн 7 дугаар Их хурал, Ерөнхий ассамблейн 8 дугаар Их хурлаар дэлхийн 143 орны архитекторуудыг нэгтгэсэн НҮБ-д хүлээн зөвшөөрөгдсөн Олон Улсын Архитекторуудын Холбоо /UIA/-нд элсэж гишүүн байгууллагаар бүртгэгдсэн байна.

БНХАУ-ын нийслэл Бээжин хотноо 1991 онд зохион байгуулсан Азийн 15 орныг эгнээндээ багтаасан Азийн архитекторуудын бүсийн зөвлөл (АРКАЗИА)-ийн зөвлөл-



дөх хурлаар гишүүн байгууллагаар элссэн нь МАЭ-ийн гишүүд бүс нутгийн архитекторуудын эвлэлийн үйл ажиллагаа, архитектурын оюутнуудын цугларалтад оролцох, өөрийн орны архитектурын бүтээлийг хэвлүүлэх, шилдэг бүтээлийн уралдаанд оролцох зэрэг өргөн боломж нээгдсэн.

2009, 2022 онуудад Азийн Архитекторуудын бүсийн Зөвлөл ARCASIA-ийн зөвлөлдөх уулзалтыг, 2013 онд Олон Улсын Эмэгтэй архитекторуудын чуулга уулзалтыг өөрийн оронд зохион байгуулж “Уул амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулахад архитекторуудын үүрэг оролцоо” сэдвээр зохион байгуулж Улаанбаатарын тунхаглал гарган нийтийг уриалсан.

Эвлэл нь Төрийн зарим чиг үүргийг 2016 оноос гэрээний үндсэн дээр гүйцэтгэж ирсэн байна. Үүнд:

- Архитекторуудын давтан сургалт, мэргэшлийн зэрэг олгох, ахиулах үйлчилгээ;
- Хот төлөвлөлт, архитектурын орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулах үйлчилгээг эрхэлж байна.

МАЭ нь БХБ-ын сайдын 2017 оны 200 дугаар тушаалаар баталсан “Барилгын салбарын ажилтны давтан сургалт, мэргэшлийн зэрэг олгох дүрэм” (цаашид БСАДСМЗОД гэх)-ийн 3.4-т заасан “Сургалт эрхлэгч” байгууллагын чиг үүргийг ХББОСЯ-тай төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэхээр 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 2025/50 дугаартай “Архитектор, хот төлөвлөлтийн мэргэжилтнийг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх сургалтын чиг үүргийг үргэлжлүүлэн гүйцэтгүүлэх” гэрээгээр баталгаажуулж, 3 жилийн хугацаанд тус үйл ажиллагааг гүйцэтгэхээр заасан.

2025/50 дугаартай гэрээнд ХББОСЯ-ны хариуцсан эрх, үүргийн 4 заалттай, МАЭ-ийн хариуцсан эрх, үүргийн 5 заалттай.

Эвлэл нь байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангуулахаар БСАДСМЗОД-ийн 3.6.2-т зааснаар 2025 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөөний төслөө “Барилгын салбарын ажилтны мэргэшил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох орон тооны бус зөвлөл”-ийн 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн дэмжигдэж 03/2025 шийдвэр гарчээ.

Орон тооны бус зөвлөлийн хурлын 03/2025 дугаар шийдвэрийн дагуу ХББОСЯ-ны ТНБД-ын 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/99 дугаартай “сургалтын нэгдсэн төлөвлөгөө батлах тухай” тушаалын нэгдүгээр хавсралтаар МАЭ-ийн зохион байгуулах сургалтын төлөвлөгөө батлагдсан.

Сургалтын төлөвлөгөөгөөр Хот төлөвлөлт, хот төлөвлөлтийн эдийн засаг, ландшафт, барилгын эзэлхүүн төлөвлөлт, сэргээн засалт гэсэн 5 хүрээнд мэргэшлийн мэргэшсэн болон зөвлөх зэрэг горилх, сунгах шаталбарын 24 чиглэлээр 48 удаагийн сургалтыг МАЭ-ийн өөрийн байранд, танхимаар зохион байгуулахаар төлөвлөсөн.

Гэрээгээр МАЭ-нь БСАДСМЗОД-ийг мөрдөж ажиллахаар заасны дагуу тус дүрэмд сургалт эрхлэгч байгууллагын хувьд мөрдөх нийт 15-н заалт байна.

ГУРАВ.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

МАЭ-ийн ХББОСЯ-тай байгуулсан “Архитектор, хот төлөвлөлтийн мэргэжилтнийг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх сургалтын чиг үүргийг гүйцэтгүүлэх тухай” 2025/50 дугаартай гэрээ, ХББОСЯ-ны ТНБД-ын 2025 оны А/99 дугаартай тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан сургалтын нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтийг МАЭ-ээс 2025 оны 12/63 дугаартай албан бичгийн хавсралтаар ирүүлсэн “Барилгын салбарын хот төлөвлөлт, архитектурын чиглэлийн мэргэжилтнийг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх багц цаг тооцох” сургалт зохион байгуулж, гүйцэтгэсэн тайланг үндсэн материал болгон хяналт-шинжилгээ, үнэлгээг хийв.

Үнэлгээг “Архитектор, хот төлөвлөлтийн мэргэжилтнийг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх сургалтын чиг үүргийг үргэлжлүүлэн гүйцэтгүүлэх” 2025 оны 2025/50 дугаар гэрээний, БСАДСМЗОД-ийн, ХББОСЯ-ны ТНБД-ын 2025 оны А/99 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “МАЭ-ээс 2025 онд зохион байгуулах барилгын салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг горилох, сунгах сургалтын нэгдсэн төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ыг үндэслэл болгон баримталж, тус журмын 3 дахь хэсэгт заасан “Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнах, хяналт-шинжилгээ хийх” хэсгээр тооцон хийлээ.

- МАЭ-ийн БСАДСМЗОД-ийн сургалт эрхлэгч байгууллагын чиг үүргийг 1.1, 1.2, 1.3, 1.4, 1.23 хүрээнд хэрэгжүүлэхээр ХББОСЯ-тай байгуулсан 2025/50 дугаартай 3 жилийн хугацаатай байгуулсан гэрээний 2025 оны хэрэгжилт ХББОСЯ-ны эрх үүргийн хэмжээнд 4 заалтын хэрэгжилт **83.33**, МАЭ-ийн эрх үүргийн 5 заалтын хэрэгжилт **75**, нийт 9 заалтаар **78.6** хувьтай үнэлэгдлээ. Үүнд: Бүрэн хэрэгжилттэй 3, дутуу хэрэгжилттэй 3, хэрэгжээгүй 1, хугацаа болоогүй 1, эрхлэх асуудалд хамааралгүй 1 нийт 9 заалт байна.
- Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 200 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан БСАДСМЗОД-ийн “сургалт эрхлэгч байгууллага”-ийн мөрдөх 15 заалтын хэрэгжилт **75** хувьтай үнэлэгдлээ. Үүнд: бүрэн хэрэгжсэн 10, хэрэгжилт бүрэн хангагдаагүй 1, хэрэгжүүлж ажиллаагүй 3, үнэлгээнээс хассан 1 заалт байна.
- ХББОСЯ-ны ТНБД-ын 2025 оны А/99 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “МАЭ-ээс 2025 онд зохион байгуулах барилгын салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг горилох, сунгах сургалтын нэгдсэн төлөвлөгөө”-ний хэрэгжилт 74.35 хувьтай үнэлэгдлээ. Үүнд: тайлант жилд нийт мэргэшлийн 5 хүрээгээр, мэргэшсэн болон зөвлөх, тэргүүлэх зэргийн 3 шатны 9 төрлийн 47 удаагийн сургалт төлөвлөснөөс 5 төрлийн 38 сургалтыг амжилттай зохион байгуулсан сургалтад 248 архитектор, хот төлөвлөлтийн эдийн засагчид зэрэг горилох, зэргээ сунгахаар хамрагдсан байна.

Хүснэгт-1: Үнэлгээний нэгдсэн товчоо /хувиар/

№	Нэр	Заалтын тоо	Хэрэгжилтийн хувь					Биелэлт (хувиар)
			100	50	0	ХБ	ҮХ	
1	2050/50 дугаартай гэрээ	9	4	3	0	1	1	78.57
2	Барилгын салбарын ажилтны давтан сургалт, мэргэшлийн зэрэг олгох дүрэм	15	10	1	3	-	1	75
3	МАЭ-ээс 2025 онд зохион байгуулах барилгын салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг горилох, сунгах сургалтын нэгдсэн төлөвлөгөө	9	5	0	4	-	-	55.56
		47	38	-	9	-	-	80.85
		4	3	-	1	-	-	82.5
		5	2	-	2	-	-	78.5
	БҮГД	89	62	4	19	1	2	75.97

Тайлбар: ХБ-хугацаа болоогүй,
ҮХ-үнэлгээнээс хассан.

Хүснэгт-2: Гэрээ, дүрэм, төлөвлөгөөний заалт, арга хэмжээний биелэлтийн нэгтгэл

Дугаар	гүйцэтгэл	Дугаар	гүйцэтгэл	Дугаар	гүйцэтгэл	Дугаар	гүйцэтгэл
0	1	0	1	0	1	0	1
Гэрээ	78.57	3.6.5	1	1.1.21	1	1.4.1	0
2	83.33	3.6.6	1	1.1.22	1	1.4.11	0
2.1	1	3.6.7	-	1.1.23	1	1.4.12	0
2.2	0.5	3.6.8	1	1.2	100	1.4.13	0
2.3	-	3.6.9	1	1.2.1	100	1.4.2	0
2.4	1	3.6.10	1	1.2.11	1	1.4.21	0
3	75	3.8	1	1.2.12	1	1.4.22	0
3.1	0.5	3.9	1	1.2.13	1	1.4.23	0
3.2	0.5	3.10	1	1.2.2	100	1.23	50
3.3	1	3.11	1	1.2.21	1	1.23.1	100
3.4	-	4.6	0	1.2.22	1	1.23.11	1
3.5	1	төлөвлөгөө	74.35	1.2.23	1	1.23.12	1
Дүрэм	75.00	1.1	1	1.3	0	1.23.13	1
3.6	72.2	1.1.1	100	1.3.2	0	1.23.2	0
3.6.1	1	1.1.11	1	1.3.21	0	1.23.21	0
3.6.2	0.5	1.1.12	1	1.3.22	0	1.23.22	0
3.6.3	0	1.1.13	1	1.3.23	0	1.23.23	0
3.6.4	0	1.1.2	100	1.4	0	БҮГД	75.97



А. ГЭРЭЭНИЙ ҮҮРГИЙН ҮНЭЛГЭЭ

Хүснэгт-3: Гэрээний хэрэгжилтийн нэгдсэн товчоо /хувиар/

Зүйл №	Гэрээний хариуцах тал	Заалтын тоо	Хэрэгжилтийн хувь					Биелэлт (хувиар)
			100	50	0	ХБ	ҮХ	
2	ХББОСЯ-ны эрх үүрэг	4	2	1	-	1	-	83.33
3	МАЭ-ийн эрх үүрэг	5	2	2	-	-	1	75
	БҮГД	9	4	3	0	1	1	78.57

Хүснэгт-4: Гэрээний 2 ба 3 дугаар зүйлийн хэрэгжилт /хувь/

Дугаар заалт	заалт	хэрэгжилт	Үнэлгээ
Хоёр. Яамны эрх, үүрэг			83.33
2.1	Барилгын салбарын ажилт-ныг давтан сургах, мэргэ-жил дээшлүүлэх, мэргэш-лийн зэрэг олгох ажлыг зо-хион байгуулах, сургалт эрхлэхтэй холбоотой хууль, тогтоомж, бодлогын баримт бичиг, төсөл хөтөлбөр боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэхэд зохион байгуу-лагч МАЭ-ийн оролцоог хангаж, хамтран ажиллана.	Яамнаас МАЭ-д 2025 онд 12 албан бичг хүргүүлснээс хууль эрх зүйн төсөлд санал авахаар 5, бодлогын баримт бичиг, төсөл хөтөлбөр боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгт төлөөлөгч оролцуулах тухай 2 албан бичиг хүргүүлсэн байна. МАЭ-ээс хууль, дүрэм, журмын төсөлд 3 удаагийн албан бичгээр санал ирүүлж, хууль, эрх зүйн баримт бичиг боловсруу-лах 2 ажлын хэсэгт болон орон тооны бус зөвлөлийн гишүүнээр нэр өгч ажилласан байна.	1
2.2	Хууль тогтоомж, тушаал шийдвэрийн хэрэгжилт бо-лон гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтэд хагас, бүтэн жилээр дүгнэж, хя-налт тавьж ажиллана	МАЭ-ээс 2025 оны хагас жилийн тайланг 2025.06.19-ны 06/33, жилийн тай-ланг 2025.12.11-ний 12/63 дугаар албан бичгүүдээр ирүүлсэн боловч гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийг дүгнээгүй байна. МАЭ-ийн 2025 оны бүтэн жилийн үйл ажиллагаанд хийж байгаа энэхүү ХШҮ-ээр тооцож үнэлгээг өглөө.	0.5
2.3	Энэ гэрээний 2.2-т заа-сан ажлын санал, дүгнэл-тийг ХББОС-ын сайдад танил-цуулж, сунгах эсэх асууд-лыг шийдвэрлүүлнэ.	Гэрээний сунгах эсэх асуудал хугацаа болоогүй байгаа тул үнэлгээнээс хасав.	-
2.4	Энэ гэрээний 4.2-т заасны дагуу гэрээг цуцлах асууд-лыг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ	МАЭ-ээс гэрээний 4.2-т заасан сөрөг нөх-цөл байдлыг үүсгээгүй.	1
Гурав. МАЭ-ийн эрх, үүрэг			75
3.1	Энэхүү гэрээнд заасан Ба-рилгын салбарын ажилт-ныг давтан сургах, мэргэ-жил дээшлүүлэх, мэргэш-	Төрийн зарим чиг үүргийг төлөөлөн хэрэгжүүлэхээр байгуулсан сургалтын үйл ажиллагааг зохион байгуулсан бөгөөд	0.5

Дугаар заалт	заалт	хэрэгжилт	Үнэлгээ
	лийн зэрэг олгох, сунгах зэрэг ажлыг зохион байгуулах чиг үүргээ гүйцэтгэхдээ төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчмыг удирдлага болгоно	зохион байгуулагч байгууллагын шалгалтын цахим системд гэрээний дагуу хэрэгжүүлж байгаа хүрээгээр шалгалтын төлөвлөгөө, нөхцөл шаардлага, бүрдүүлэх баримт бичгүүд орсон байна. Дүрмийн 3.6-д болон 4.6-д заасан зохион байгуулагч талтай хамтран ажиллах, холбогдох мэдээллийг хүргүүлэх, санал танилцуулах, шалгалтын тест боловсруулан хүргүүлэх, сургалтын ажилд ХШҮ хийлгэсэн байх зэрэг ажлууд хийгдээгүй байна.	
3.2	Барилгын салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх тогтолцоог боловсронгуй болгох, сургалтын чанар, ажилтнуудын ур чадварыг нэмэгдүүлэх, мэргэшлийн зэрэг олгох ажлыг боловсронгуй болгох, оновчтой зохион байгуулах санал, санаачлага гаргаж, эрх хэмжээнийхээ хүрээнд хэрэгжүүлэх, бусад шаардлагатай асуудлаар яаманд санал тавьж шийдвэрлүүлнэ.	Сургалт эрхлэгч МАЭ-ээс 2025 оны 2 дугаар сард санал асуулга явуулсан. Санал асуулгад 130 архитектор, хот байгуулалтын эдийн засагч нар хамрагдсан. Санал асуулгын үр дүнд: 1. Хот байгуулалтын кадастрийн цахим систем, түүний хэрэглээ 2. GIS мэдээллийн сан 3. BIM Building information modeling олон улсын туршлага 4. FAR, BCR-ын тухай ойлголт, Floor area ratio, Building coverag ratio, 5. Хот төлөвлөлтийн тогтвортой 5 зарчим гэсэн сэдвүүдээр сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан байна. Ирүүлсэн тайланд “Бакалаврын дараах дадлагажих сургалт зохион байгуулахаар сургалтын төлөвлөгөөг батлуулсан ба хичээлийн хөтөлбөр төлөвлөгөө хийгдсэн” гэсэн боловч нотлох баримтыг ирүүлээгүй.	0.5
3.3	Сургалт зохион байгуулах зардал буюу мэргэжил дээшлүүлэх сургалтын төлбөрийн жишиг хэмжээг зөвлөлөөр батлуулна. Төлбөрт элсэгчийг бүртгэх, сургалт зохион байгуулахтай холбоотой зардал багтана.	“Зөвлөл”-ийн шийдвэрээр ХББОСЯ-ны ТНБД-ын 2025.05.30-ны А/99 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлуулсан “МАЭ-ээс 2025 онд зохион байгуулах сургалтын нэгдсэн төлөвлөгөө”-ний 7 дугаар баганаар сургалтын нэр бүрээр сургалтын төлбөрийн хэмжээг батлуулжээ.	1
3.4	Сургалт зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлэх-дээ сургалт эрхлэх чиг үүрэг хүлээсэн түншлэгч байгууллагуудын мэргэжил дээшлүүлэх сургалтуудыг нэгтгэн төлөвлөж, зохион байгуулах ажлыг нь мэргэ-	Энэхүү заалт нь Сургалт эрхлэгч байгууллагад үл хамаарах, зохион байгуулагч байгууллагад хамаарах заалт байгаа тул үнэлгээнээс хасаж тооцов.	-



**ХОТ БАЙГУУЛАЛТ,
БАРИЛГА, ОРОН
СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМ**

Дугаар заалт	заалт	хэрэгжилт	Үнэлгээ												
	жил арга зүйн удирдлагаар хангаж зохион байгуулна.														
3.5	БХБ-ын сайдын 2017 оны 200 дугаар тушаалаар батлагдсан БСАДСМЗОД-ийг мөрдөж, дүрмийн 1-р хавсралтын үйл ажиллагааны хүрээ 1.1, 1.2, 1.3, 1.4, 1.23-т заасан барилгын салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох, сунгах, сургалт зохион байгуулах, эрхлэх чиг үүргийг хэрэгжүүлж ажиллана.	БСАДСМЗОД-ийн хэрэгжилтийг хүснэгт 5-р, дүрмийн 1 дүгээр хавсралтын 1.1, 1.2, 1.3, 1.4, 1.23 хүрээгээр гүйцэтгэсэн ажлыг ХББОСЯ-ны ТНБД-ын 2025 оны А/99 дугаар тушаалаар баталсан нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлсэн хүснэгт 6-р тус тус үнэлэв. <table><tr><th>№</th><th>Нэр</th><th>Үнэлгээ</th></tr><tr><td>1</td><td>БСАДСМЗОД-ийн хэрэгжилтийн үнэлгээ</td><td>75.00</td></tr><tr><td>2</td><td>Сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ</td><td>74.35</td></tr><tr><td colspan="2">БҮГД</td><td>74.67</td></tr></table>	№	Нэр	Үнэлгээ	1	БСАДСМЗОД-ийн хэрэгжилтийн үнэлгээ	75.00	2	Сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ	74.35	БҮГД		74.67	0.75
№	Нэр	Үнэлгээ													
1	БСАДСМЗОД-ийн хэрэгжилтийн үнэлгээ	75.00													
2	Сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ	74.35													
БҮГД		74.67													
		БҮГД	78.57												

ХББОСЯ-ны хүлээсэн 4 заалтаас бүрэн хэрэгжсэн 2, хагас хэрэгжсэн 1, хугацаа болоогүй 1 заалт байна гэж дүгнээд хэрэгжилтийг бодоход:

$$\text{Хэрэгжилтийн дүн} = \frac{\text{Хэрэгжүүлсэн заалтын тоо } \mathbf{2+0.5}}{((\text{Нийт заалтын тоо})-(\text{хугацаа болоогүй заалтын тоо})) \mathbf{(4-1)}} \times 100 = \mathbf{83.33\%}$$

МАЭ-ийн хүлээсэн 5 заалтаас бүрэн хэрэгжсэн (0.8-аас 1) 2, хагас хэрэгжилттэй 2, үнэлгээнээс хассан 1 заалт байна гэж дүгнээд хэрэгжилтийг бодоход:

$$\text{Хэрэгжилтийн дүн} = \frac{\text{Хэрэгжүүлсэн заалтын тоо } \mathbf{2+0.5 \times 2}}{((\text{Нийт заалтын тоо})-(\text{хугацаа болоогүй заалтын тоо})) \mathbf{(5-1)}} \times 100 = \mathbf{75\%}$$

Нийт гэрээний эрх үүргийн 9 заалтаас бүрэн хэрэгжсэн 4, хагас хэрэгжсэн 3, үнэлгээнээс хассан 2 заалт байна гэж дүгнээд хэрэгжилтийг бодоход:

$$\text{Хэрэгжилтийн дүн} = \frac{\text{Хэрэгжүүлсэн заалтын тоо } \mathbf{4+0.5 \times 3}}{((\text{Нийт заалтын тоо})-(\text{хугацаа болоогүй заалтын тоо})) \mathbf{(9-2)}} \times 100 = \mathbf{78.6\%}$$



**Б. МАЭ-ИЙН “БАРИЛГЫН САЛБАРЫН АЖИЛТНЫ ДАВТАН СУРГАЛТ, МЭРГЭШ-
ЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ ДҮРЭМ”-ИЙН СУРГАЛТ ЭРХЛЭГЧ БАЙГУУЛЛАГАД ХАМАА-
РАХ ЗААЛТУУДЫГ ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ**

Хүснэгт-5: БСАДСМЗОД-ийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээ

Дугаар заалт	заалт	хэрэгжилт	Үнэлгээ
3.6.	Сургалт эрхлэгч байгууллага нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:		72.22
3.6.1	давтан сургалт, мэргэжил дээшлүүлэх гэрээг Барилгын тухай хуулийн 36.1-д заасны дагуу байгуулж ажиллах;	“Барилгын салбарын ажилтны давтан сургалт, мэргэшлийн зэрэг олгох дүрэм”-ийн 3.4-т заасан “Сургалт эрхлэгч” байгууллагын чиг үүргийг ХББОСЯ-тай төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэхээр 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 2025/50 дугаартай “Архитектор, хот төлөвлөлтийн мэргэжилтэнийг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх сургалтын чиг үүргийг үргэлжлүүлэн гүйцэтгүүлэх” 3 жилийн хугацаатай гэрээг байгуулсан.	1
3.6.2	зохион байгуулах багц цагийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг гаргаж зохион байгуулагч байгууллагад 12 дугаар сарын 10-ны дотор хүргүүлэх;	МАЭ-ээс 2025 онд зохион байгуулах сургалтын нэгдсэн төлөвлөгөөг “Зөвлөл”-ийн шийдвэрээр ХББОСЯ-ны ТНБД-ын 2025.05. 30-ны А/99 дугаар тушаалын 1-р хавсралтаар батлуулсан. Сургалтын хөтөлбөр батлуулсан баримт байхгүй, ирүүлээгүй болно.	0.5
3.6.3	зохион байгуулсан багц цагийн сургалтын агуулгаар 30-аас доошгүй шалгалтын тест боловсруулж зохион байгуулагч байгууллагад тухайн сургалтын тайлангийн хамт хүргүүлэх.	Тайлант онд шалгалтын тест боловсруулаагүй байна. МАЭ-ээс шалгалт зохион байгуулдаггүй тул тестийн материал бэлтгээгүй гэсэн тайлбар өгөв.	0
3.6.4	сургалтад оролцож, шаардлагатай багц цаг хангасан сургалтын тайланг сургалт дууссанаас хойш ажлын 10 өдөрт багтаан зохион байгуулагч байгууллагад хүргүүлэх;	ХББОСЯ-ны Зохион байгуулагч МБИХ-той байгуулсан 2024.09.11-ний өдрийн 2024/54, АГ02/2024 дугаартай гэрээний 3.6-аар зохион байгуулагч байгууллагын эрх үүргийн хэмжээнд зөвхөн дүрмийн 3.5 дах хэсгийн 6, 7, 10, 11, 13 дах заалтуудыг хэрэгжүүлэхээр, 1.1, 1.2, 1.3, 1.4, 1.23 хүрэнээс бусад хүрээгээр сургалт эрхлэхээр тусгасан байгаа бөгөөд МАЭ-ээс зохион байгуулагч байгууллагын бүрэн эрх бүтнээрээ МБИХ-д очоогүй байгаа тул тайланг хүргүүлдэггүй гэж тайлбар өгсөн.	0
3.6.5	гэрээний үндсэн дээр зохион байгуулах багц цагийн сургалтад энэ дүрмийн хавсралт 1-д заасан шаардлагыг хангасан мэргэжилтэнг бүртгэх, материалын	Энэхүү заалт нь мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг горилох, сунгах шалгалтад оролцохтой холбоотой заалт бөгөөд тавьсан шаардлага, нөхцөлийг хангаж амжаагүй боловч өөрсдийн ур чадвар,	1

Дугаар заалт	заалт	хэрэгжилт	Үнэлгээ
	бүрдэл, эх сурвалжид хяналт тавих;	мэдлэг мэдээллээ нэмэгдүүлэх зорилготой архитектор, инженер, эдийн засагч нарт сургалтад оролцох боломжийг хангах нь зүйтэй гэж үзэж байна. 1.1, 1.2, 1.3, 1.4, 1.23 хүрээгээр зохион байгуулагч байгууллагын “шалгалт зохион байгуулах” чиг үүргийг гэрээний үндсэн гүйцэтгэж байгаа “МБИХ” ТББ-ийн түншлэлийн нэвтрүүлсэн цахим систем /shalgalt.mce. mn/-д бүрдлийг хянан авдаг болсон байна.	
3.6.6	сургалтыг зориулалтын анги, танхимд зохион байгуулах, материал, тоног төхөөрөмжөөр хангах;	МАЭ-ийн төв байранд тохижуулсан сургалтын танхимуудаар сургалт зохион байгуулдаг.	1
3.6.7	Зөвлөлөөс болон зохион байгуулагч байгууллагаас ирүүлсэн санал, зөвлөмж, шаардлагыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах	Зөвлөл болон зохион байгуулагч байгууллагаас ямар нэгэн санал зөвлөмж хүргүү-лээгүй байна. Үнэлгээнээс хассан	-
3.6.8	Багц цагийн сургалтын талаар судалгаа хийх, дотоод хяналт тавих, санал асуулга авч үйл ажиллагаандаа тусгаж ажиллах;	Сургалт эрхлэгч МАЭ-ээс 2025.2-р сард санал асуулга явуулсан. Санал асуулгад 130 архитектор, хот байгуулалтын эдийн засагч нар хамрагдсаны үр дүнд: 1. Хот байгуулалтын кадастрийн цахим систем, түүний хэрэглээ 2. GIS мэдээллийн сан 3. BIM Building information modeling олон улсын туршлага 4. FAR, BCR-ын тухай ойлголт, Floor area ratio, Building coverag ratio, Хот төлөвлөлтийн тогтвортой 5 зарчим гэсэн сэдвүүдээр сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан гэж тайлбар өгөв.	1
3.6.9	зохион байгуулсан сургалтын материалыг архивын нэгж болгон хадгалах;	Архивын материал болгон хадгалсан.	1
3.6.10	мэргэжил дээшлүүлэх тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр санал боловсруулж, зохион байгуулагч байгууллагад хүргүүлэх.	Сургалт эрхлэгч МАЭ-ээс 2025.2-р сард санал асуулга явуулсан. Санал асуулгад 130 архитектор, хот байгуулалтын эдийн засагч нар хамрагдсаны үр дүнд: 5. Хот байгуулалтын кадастрийн цахим систем, түүний хэрэглээ 6. GIS мэдээллийн сан 7. BIM Building information modeling олон улсын туршлага 8. FAR, BCR-ын тухай ойлголт, Floor area ratio, Building coverag ratio,	1



**ХОТ БАЙГУУЛАЛТ,
БАРИЛГА, ОРОН
СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМ**

Дугаар заалт	заалт	хэрэгжилт	Үнэлгээ
		Хот төлөвлөлтийн тогтвортой 5 зарчим гэсэн сэдвүүдээр сургалтын төлөвлөгөөнд тусгагдан ХББОСЯ-ны ТНБД-ын 2025 оны А/99 дугаар тушаалаар батлуулсан.	
3.8	Сургалт нь тухайн мэргэжилтний мэргэшлийн зэрэгтэй уялдаж, салбарын эрэлт, хэрэгцээнд тулгуурласан, агуулгын хувьд суралцагсдад онолын болон дадлагын мэдлэг, ур чадвар олгоход чиглэсэн байна.	Сургалтын төлөвлөгөө, агуулгыг ХББОСЯ-ны ТНБД-ын 2025 оны А/99 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлуулсан	1
3.9	Сургалтын хөтөлбөрт сургалтын нэр, төрөл, мэргэшүүлэх чиглэл, зорилго, агуулга, арга зүй, цагийн багтаамж, олгогдох багц цаг, санхүүжилт, төлбөрийн хэмжээ, сургагч багшид тавигдах шаардлага, сургалтад хамрагдах мэргэжилтний үйл ажиллагааны хүрээ, тоо, сургалт явагдах газар, хугацаа, сургалтын хэрэглэгдэхүүн /гарын авлага, тараах материал/, шалгалтын хэлбэрийг тусгасан байна.	Сургалтын хөтөлбөрийг орон тооны бус “Зөвлөл”-өөр хэлэлцүүлэн батлуулаагүй. Өмнөх гэрээ, сонгон шалгаруулсан нөхцөлийн хүрээнд үйл ажиллагааг эрхэлж байгаа гэж үзэн үнэллээ	1
3.10	Сургалтын төлөвлөгөөг жил бүр шинэчлэн боловсруулах ба түүнд сургалтын төрөл, чиглэл, сэдэв, сургалт эрхлэх хэлбэр, хугацааг нарийвчлан тусгана. Сургалт нь заавал болон сонгон сурах гэсэн 2 төрөлтэй байна.	ХББОСЯ-ны ТНБД-ын 2025 оны А/99 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлуулсан	1
3.11	Сургалтын хичээл заах багш нь магистр, түүнээс дээш зэрэгтэй, багшлах туршлагатай байна.	Нийт 27 архитектор, ИТА нийт 47 сэдвээр хичээл орсноос 4 доктор, 1 докторант, 22 нь магистр зэрэгтэй байна.	1
4.6	Сургалт эрхлэгч байгууллага сургалтын төлөвлөгөөний дагуу өөрийн хариуцсан чиглэлийн сургалтыг зохион байгуулах бөгөөд сургалтад хамрагдсан иргэдийн материалыг зохион байгуулагч байгууллагад хүргүүлнэ.	Сургалтад хамрагдсан архитектор, инже-нер, эдийн засагчид шалгалт зохион байгуулагч МБИХ-нд өөрсдөө очиж бүртгүүлдэг.	0
		БҮГД	75.0



Үнэлэх 15 заалтаас бүрэн хэрэгжсэн 10, хагас хэрэгжсэн 1, хэрэгжүүлээгүй 3, үнэлгээнээс хассан 1 заалт байна.

$$\text{Хэрэгжилтийн дүн} = \frac{\text{Хэрэгжүүлсэн заалтын тоо (10+0.5)}}{((\text{Нийт заалтын тоо})-(\text{хугацаа болоогүй заалтын тоо})) (15-1)} \times 100 = 75\%$$

Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 200 дугаар тушаалын хавсралтаар баталсан БСАДСМЗОД-ийн сургалт эрхлэгч байгууллагад хамааралтай 15 заалтаар үнэлгээ хийхэд хэрэгжилт хангалтгүй буюу хэрэгжүүлээгүй (3.6.3, 3.6.4, 4.6) 0 хувийн гүйцэтгэлтэй 3, МАЭ-ээс үл хамаарсан хэрэгжих боломжгүй (3.6.7) 1, хугацаандаа хэрэгжээгүй буюу 50%-ийн хэрэгжилттэй (3.6.2) 1, бүрэн хэрэгжүүлсэн 100 хувь гүйцэтгэлтэй 10 заалт, нийт дүрмийн хэрэгжилт 75 хувьтай гэж үнэлэгдлээ.

В. ХББОСЯ-НЫ ТНБД-ЫН 2025 ОНЫ А/99 ДУГААР ТУШААЛЫН НЭГДҮГЭЭР ХАВСРАЛТ “МАЭ-ЭЭС 2025 ОНД ЗОХИОН БАЙГУУЛАХ БАРИЛГЫН САЛБАРЫН АЖЛТНЫ МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ, МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ ГОРИЛОХ, СУНГАХ СУРГАЛТЫН НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ

ХББОСЯ-ны ТНБД-ын 2025 оны А/99 дугаар тушаалаар баталсан “МАЭ-ээс 2025 онд зохион байгуулах барилгын салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг горилох, сунгах сургалтын нэгдсэн төлөвлөгөө”-ний хэрэгжилт 74.35 хувиар үнэлэгдлээ

Хүснэгт-6: Батлагдсан сургалтын төлөвлөгөөний нэгдсэн үнэлгээ.

№	НЭР	ҮНЭЛГЭЭ
1	Мэргэшлийн хүрээний төлөвлөгдсөн сургалтын үнэлгээ	55.56
2	Төлөвлөгдсөн шатлалын сургалтуудын үнэлгээ	80.85
3	Мэргэшсэн зэргийн горилох, сунгах сургалт	82.50
4	Зөвлөх, тэргүүлэх зэргийн горилох, сунгах сургалт	78.50
	БҮГД	74.35

Төлөвлөгөөнд 5 хүрээгээр 9 чиглэлээр сургалт хийгдэхээс 3 хүрээний 5 чиглэлийн сургалт амжилттай зохион байгуулагдаж хэрэгжилт 55.56%-аар үнэлсэн.

Хүснэгт-7: Мэргэшлийн хүрээний төлөвлөгдсөн сургалтын үнэлгээ

Хүрээ	Мэргэшсэн		Зөвлөх		Нийт	
	Төлөвлөсөн	Гүйцэтгэл	Төлөвлөсөн	Гүйцэтгэл	Төлөвлөсөн	Гүйцэтгэл
1.1	1	1	1	1	2	2
1.2	1	1	1	1	2	2
1.3	0	0	1	0	1	0
1.4	1	0	1	0	2	0
1.23	1	1	1	0	2	1
Нийт	4	3	5	2	9	5
Хэрэгжилт /хувь/		75.00		40.00		55.56

$$\text{Хэрэгжилтийн дүн} = \frac{\text{Хэрэгжүүлсэн заалтын тоо } 5}{((\text{Нийт заалтын тоо}) - (\text{хугацаа болоогүй заалтын тоо})) (9-0)} \times 100 = 55.56\%$$

Хүснэгт-8: Төлөвлөгдсөн шатлалын сургалтуудын хэрэгжилтийн үнэлгээ

Хүрээ	мэргэшсэн		Зөвлөх		Нийт	
	Төлөвлөсөн сургалтын тоо	гүйцэтгэл	Төлөвлөсөн сургалтын тоо	гүйцэтгэл	Төлөвлөсөн сургалтын тоо	гүйцэтгэл
1.1.1	2	2	2	2	4	4
1.1.2	2	2	2	2	4	4
1.1.3	2	2	2	2	4	4
1.2.1	3	4	3	4	6	8
1.2.2	3	4	3	4	6	8
1.2.3	3	4	3	4	6	8
1.3.1	0	0	2	0	2	0
1.3.2	0	0	2	0	2	0
1.3.3	0	0	2	0	2	0
1.4.1	1	0	1	0	2	0
1.4.2	1	0	1	0	2	0
1.4.3	1	0	1	0	2	0
1.23.1	1	1	1	0	2	1
1.23.2	1	1	1	0	2	1
1.23.3	0	0	1	0	1	0
Нийт	20	20	27	18	47	38
ҮНЭЛГЭЭ		100.00		66.67		80.85

Тайлбар: Хүрээний дугаарлалтын сүүлийн оронгийн дугаарлалт нь мэргэшлийн зэргийн горилох, нэгдэх болон хоёрдох сунгалтыг, өмнөх дугаарлалт нь дүрэмд заасан мэргэшлийн хүрээний дугаарыг заахаар тэмдэглэсэн болно. Үүнд:

- АА.АА.1 мэргэшлийн зэргийн горилохын,
- АА.АА.2 мэргэшлийн зэргийн нэгдүгээр сунгалтын,
- АА.АА.3 мэргэшлийн зэргийн хоёрдугаар сунгалтын.

Үнэлгээг батлагдсан төлөвлөгөөнд заасан сургалт зохион байгуулсан эсэхийг мэргэшсэн болон зөвлөх, тэргүүлэх зэргээр ангилан “хүснэгт-9”, “хүснэгт-10”-аар үнэлэв.



Хүснэгт-9: Мэргэшсэн зэргийн горилох, сунгах сургалтын хэрэгжилт

№	Хүрээ	Төлөвлөсөн хугацаа	Зохион байгуулсан хугацаа	Хамрагсадын тоо		Хэрэгжилт Хувь
				Горилох	Сунгах	
1.1	Хот төлөвлөлт	IV, X	V, X	12	18	100
1.2	Барилгын архитектур /эзлэхүүн/ төлөвлөлт	III, V, IX	IV, V, IX, XI	77	96	133
1.4	Сэргээн засалт	XI	-	-	-	0
1.23	Хот төлөвлөлтийн эдийн засагч	X	X	8	6	100
БҮГД		7	7	97	120	82.5
				217		

Хүснэгт-10: Зөвлөх, тэргүүлэх зэргийн горилох, сунгах сургалтын хэрэгжилт

№	Хүрээ	Төлөвлөсөн хугацаа	Зохион байгуулсан хугацаа	Хамрагсадын тоо		Хэрэгжилт Хувь
				Горилох	Сунгах	
1.1	Хот төлөвлөлт	IV, X	V, X	4	2	100
1.2	Барилгын архитектур /эзлэхүүн/ төлөвлөлт	III, V, IX	IV, V, IX, XI	12	13	133
1.3	Ландшафт	IV, X	-	-	-	0
1.4	Сэргээн засалт	XI	-	-	-	0
1.23	Хот төлөвлөлтийн эдийн засагч	X	X	-	-	0
БҮГД		9	7	16	15	78.5
				31		

Сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийхэд үндсэн 5 хүрээнд мэргэшсэн, зөвлөх зэргийн горилох, сунгах 48 сургалт зохион байгуулахаар төлөвлөснөөс 42 сургалтыг зохион байгуулж, 217 мэргэшсэн, 31 зөвлөх, тэргүүлэхийн, нийт 248 архитектор, хот төлөвлөлтийн эдийн засагчид зэрэг горилох, зэргээ сунгахаар хамрагдсан байна.

Үндсэн мэргэжлийн 5 хүрээнд сургалт эрхлэхээс 1.3 “ландшафт”, 1.4 “сэргээн засал” хүрээгээр сургалт зохион байгуулаагүй байна.

Сургалтад хамрагдсан 248 архитектор, эдийн засагчдаас 1.1, 1.2, 1.23 хүрээгээр мэргэшсэн, зөвлөх зэргээр горилох, сунгах шалгалтад нийт 210 нь

хамрагдсанаас 63.8% хувь буюу 134 нь амжилттай шалгалтаа өгчээ. Эх сурвалж зохион байгуулагч байгууллагын шалгалт зохион байгуулсан тухай шалгалтын комиссын “Хот төлөвлөлт, барилга архитектур /эзлэхүүн/ төлөвлөлт, хот төлөвлөлтийн эдийн засагчийн хүрээнд мэргэшлийн зэрэг олгох, сонгох шалгалтын тайлан”

Хүснэгт-11: Мэргэжлийн зэрэг горилох, сунгах шалгалтад оролцогчдын нэгдсэн жагсаалт

Хүрээ	Зэргийн төрөл	Сургалтад хамрагдсан	1- шалгалт		2-р шалгалт	
			орсон	тэнцсэн	орсон	тэнцсэн
1.1	Мэргэшсэн зэрэг	30	31	24	24	21
	горилох	12	17	11	11	8
	сунгах	18	14	13	13	13
	Зөвлөх зэрэг	6	4	1	0	0
	горилох	4	3	0	0	0
	сунгах	2	1	1	1	1
	нийт	36	35	25	24	21
1.2	Мэргэшсэн зэрэг	173	143	134	134	90
	горилох	77	73	68	68	24
	сунгах	96	70	66	66	66
	Зөвлөх зэрэг	25	23	20	20	17
	горилох	12	14	11	11	8
	сунгах	13	9	9	9	9
	нийт	198	166	154	154	107
1.23	Мэргэшсэн зэрэг	14	9	6	6	6
	горилох	8	4	1	1	1
	сунгах	6	5	5	5	5
	Зөвлөх зэрэг	0	0	0	0	0
	горилох	0	0	0	0	0
	сунгах	0	0	0	0	0
	нийт	14	9	6	6	6
Нийт мэргэшсэн		217	183	164	164	117
Нийт горилох		97	94	80	80	33
Нийт сунгах		120	89	84	84	84
Нийт Зөвлөх		31	27	21	20	17
Нийт горилох		16	17	11	11	8
Нийт сунгах		15	10	10	10	10
Бүгд		248	210	185	184	134

Засгийн газрын 2025 оны “Журам батлах тухай” 43 дугаар тогтоолын 3-р хавсралтаар баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын 3.8-д заасан аргачлалаар тооцсон. Хэд хэдэн шалгуур үзүүлэлтээр тодорхойлогдсон заалт /3.5/-ын биелэлтийн хувийг тодорхойлохдоо шалгуур



үзүүлэлт бүрийн хэрэгжилтийг гарган тэдгээрийн архиметик дундажаар тооцож үнэлэв.

Гэрээний хэрэгжилтэд үнэлгээ хийсэн 9 заалтаас жилийн эцсийн байдлаар хэрэгжилт 50 хүртэл хувьтай 3 заалт байна. Үүнд:

1. “2.2. Хууль тогтоомж, тушаал шийдвэрийн хэрэгжилт болон гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтэд хагас, бүтэн жилээр дүгнэж, хяналт тавьж ажиллана”
2. “3.1. Энэхүү гэрээнд заасан Барилгын салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох, сунгах зэрэг ажлыг зохион байгуулах чиг үүргээ гүйцэтгэхдээ төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчмыг удирдлага болгоно”
3. “3.2. Барилгын салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх тогтолцоог боловсронгуй болгох, сургалтын чанар, ажилтнуудын ур чадварыг нэмэгдүүлэх, мэргэшлийн зэрэг олгох ажлыг боловсронгуй болгох, оновчтой зохион байгуулах санал, санаачлага гаргаж, эрх хэмжээнийхээ хүрээнд хэрэгжүүлэх, бусад шаардлагатай асуудлаар яаманд санал тавьж шийдвэрлүүлнэ”

Мөн гэрээний хэрэгжилтийг үнэлэх арга хэмжээ хэрэгжээгүй байгаатай холбоотой 2.3-т заасан “Энэ гэрээний 2.2-т заасан ажлын санал, дүгнэлтийг ХББОС-ын сайдад танилцуулж, сунгах эсэх асуудлыг шийдвэрлүүлнэ” арга хэмжээг “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын 3.7.3-т зааснаар “Хугацаа болоогүй” заалтаар тооцов.

Төрийн зарим чиг үүргийг төлөөлөн хэрэгжүүлэх тус гэрээгээр МАЭ-ийг БСАДСМЗОД-ийн 3.4-т заасан “сургалт эрхлэгч байгууллага”-ийн эрх хэмжээний үйлчилгээ үзүүлэхээр гэрээг байгуулсан бөгөөд гэрээний 3.4 дэх заалт нь тус дүрмийн 3.1-д заасан “зохион байгуулагч байгууллага”-д хамаарах заалт байгаа тул “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын 3.10.7-д зааснаар “чиг үүрэгт хамааралгүй” гэж дүгнэн үнэлгээнээс хасаж тооцов.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ:

1. ХББОСЯ-аас төрийн зарим чиг үүргийг гүйцэтгүүлэхээр МАЭ-тэй 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдөр байгуулсан “Архитектор, хот төлөвлөлтийн мэргэжилтнийг давтан сургах, мэргэшил дээшлүүлэх сургалтын чиг үүргийг гүйцэтгүүлэх тухай” 2025/50 дугаар гэрээний талуудын эрх үүргийн заалтад жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхэд гэрээний хэрэгжилт **78.57** хувьтай үнэлэгдэж байна. Үүнд:

- ХББОСЯ-ны хүлээсэн үүргийн хэрэгжилт 83.33%,
- МАЭ-ийн хүлээсэн үүргийн хэрэгжилт 75%,
- Нийт 9 заалтын хэрэгжилт 78.57 хувь.

2. Гэрээний яамны хариуцсан эрх үүргийн 2.2 дах заалтын дагуу МАЭ-ийн хууль тогтоомж, тушаал шийдвэрийн болон гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтэд хагас бүтэн жилээр дүгнэх ажлыг ХББОСЯ-аас гэрээ байгуулсан ТЗУГ хэрэгжүүлээгүй



байна. Үүнтэй холбоотойгоор гэрээний 2.3-т заасан гэрээг сунгах, цуцлах талаар санал танилцуулагдаагүй байна.

3. МАЭ-ийн эрх, үүргийн 3.4 дэх заалт “Сургалт зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлэхдээ сургалт эрхлэх чиг үүрэг хүлээсэн түншлэгч байгууллагуудын мэргэжил дээшлүүлэх сургалтуудыг нэгтгэн төлөвлөж, зохион байгуулах ажлыг нь мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж зохион байгуулна” гэсэн нь БСАДСМЗОД-д заасан зохион байгуулагч байгууллагын чиг үүрэг хамаарах заалт байгаа бөгөөд МАЭ нь дангаар сургалт эрхлэх чиг үүргийг түншлэлээр эрх авсан баримт байхгүй байна.

4. Гэрээний 1.1-д ХББОС-ын сайдын хэдэн оны, ямар дугаартай, юунд зориулж гаргасан тушаалыг хэрэгжүүлэх нь тодорхойгүй, бичилт хийгээгүй байна.

5. БСАДСМЗОД-ийн “сургалт зохион байгуулагч байгууллага” буюу МАЭ-д хамаарах 15 заалтуудын хэрэгжилт хийсэн хяналт-шинжилгээгээр 75 хувьтай үнэлэгдэв. Үүнд: Сургалт эрхлэгч байгууллагын чиг үүргийн 11, сургалттай холбоотой 4 заалтуудыг авсан.

6. Гэрээний 3.6.2-т тухайн жил зохион байгуулах сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний саналыг 12 дугаар сарын 10-ны дотор зохион байгуулагч байгууллагад гаргахаар заасан байгаа бөгөөд зөвхөн сургалтын төлөвлөгөө нь ХББОСЯ-ны ТНБД-ын 2025 оны А/99 дугаар тушаалаар батлагдсан, сургалтын хөтөлбөр нь батлагдаагүй байна.

7. Дүрэмд сургалт эрхлэгч байгууллага нь орон тооны бус зөвлөл болон зохион байгуулагч байгууллагыг мэдээллээр хангах, тэдгээрт мэдээ тайлан хүргүүлэх, санал өгөх, хөтөлбөр, төлөвлөгөөгөө батлуулах, тэдгээрээс сургалттай холбоотой өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах зэрэг заалтууд хэрэгжээгүй байна. Энэ нь дүрэмд заасан зохион байгуулагч байгууллага нь тодорхойгүй байгаатай холбоотой гэж дүгнэв. Учир нь ХББОЯ-аас төрийн зарим чиг үүргийг төлөөлүүлэн хэрэгжүүлэхээр Монголын барилгын инженерүүдийн холбоо тэргүүтэй 9 төрийн бус байгууллагатай 2024 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн 2024/54, АГ 02/2024 дугаартай “Барилгын салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох ажлыг зохион байгуулах чиг үүргийг гүйцэтгүүлэх” гэрээний 3.6-д дүрмийн зохион байгуулагч байгууллагын хамааралтай заалтуудаас 3.5.6, 3.5.7, 3.5.10, 3.5.11, 3.5.13 дах заалтуудаар дүрэмд заасан мэргэшлийн 1.1, 1.2, 1.3, 1.4, 1.23 хүрээнүүдээс бусад хүрээнд хэрэгжүүлэхээр заасан байна.

8. ХББОСЯ-ны ТНБД-ын 2025 оны А/99 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан МАЭ-ийн 2025 онд зохион байгуулах сургалтын нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 74.35 хувийн хэрэгжилттэй үнэлэгдлээ.

9. Сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд заасан 1.3, 1.4 хүрээгээр хийх сургалтууд зохион байгуулагдаагүй боловч 1.2 хүрээгээр хийсэн сургалт нь төлөвлөгдсөн сургалтын тооноос их байгаа нь зохион байгуулагдах сургалтын тоонд ойртуулсан байна.

10. Сургалтын нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлангаас мэргэшлийн зэргийн сургалтын 1 ба 2-р үеийн сунгах сургалтуудыг ялгах боломжгүй ирүүлсэн байгаа бөгөөд 1 ба 2-р үеийн сунгалтын сургалт тус тусдаа зохион байгуулагдсан эсэх нь тодорхойгүй байна.



11. Мэргэшлийн 1.3, 1.4 хүрээгээр сургалт зохион байгуулаагүй, сургалт зохион байгуулахаар нийтийн сүлжээгээр зар түгээгээгүй байгаа нь энэ хүрээгээр мэргэшлийн зэргийн захиалга, хүртээмж бага байх боломжтой байна.

12. Батлагдсан сургалтын хөтөлбөр байхгүй байгаа нь мэргэшлийн зэргийн сургалтаар ямар агуулга, чанар, хүрээг хамарсан сэдвээр хэн сургалт хийсэн нь тодорхойгүй байна.

13. Ирүүлсэн тайланд тухайн ажлыг гүйцэтгэсэн тухай нотлох баримт бичиг хавсаргаж ирүүлээгүй,

ТАВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

МАЭ-ийн төрийн зарим чиг үүргийг төлөөлөн хэрэгжүүлэхээр ХББОСЯ-тай 2025 онд байгуулсан “Архитектор, хот төлөвлөлтийн мэргэжилтнийг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх сургалтын чиг үүргийг үргэлжлүүлэн гүйцэтгүүлэх” 2025/50 дугаартай гэрээний 2025 оны хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр дараах зөвлөмжүүдийг гэрээний талуудад өгч байна. Үүнд:

1. ХББОСЯ, МАЭ хооронд байгуулсан 2025/50 дугаартай гэрээний хүрээнд:
 - Гэрээний 1.1 дэх заалтын бичиглэлийг бүрэн хийж, БСАДСМЗОД-ийн 3.4-т заасан “Сургалт эрхлэгч байгууллага”-ийн чиг үүргийг хэрэгжүүлэхээр гэж тодотгон зааж өгч, “Барилгын салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг олгох ажлыг зохион байгуулах” гэснийг хасан найруулж өөрчлөх,
 - Яамны эрх үүрэгт “зохион байгуулагч байгууллага”-аар дамжуулан үйл ажиллагааны явцын хяналт хийлгэх заалт нэмэх,
 - МАЭ-ийн эрх, үүргийн 3.4 дэх заалтыг хасах,
 - 3.5 дахь заалтыг “Барилгын салбарын ажилтны давтан сургалт, мэргэшлийн зэрэг олгох дүрэм”-ийн нэгдүгээр хавсралтын 1.1, 1.2, 1.3, 1.4, 1.23 дахь үйл ажиллагааны хүрээнд тус дүрэмд заасан “сургалт эрхлэгч байгууллага”-ын чиг үүргийг хэрэгжүүлж ажиллана” гэж найруулан өөрчлөх,
 - Зохион байгуулагч байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллагыг тодорхой болгож, сургалт эрхлэгч байгууллагаас дүрэм, журамд заасны дагуу зохион байгуулагч байгууллагатай харьцах, түүгээр үнэлүүлэх, зохион байгуулагч байгууллагад санал өгөх, мэдээ тайлангаа хүргүүлэх боломжоор хангах,
 - Сургалт эрхлэгч байгууллага нь гэрээний хэрэгжилтийн тайланг гэрээний заалтаар, БСАДСМЗОД-ийн хамаарах заалтуудаар, Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний заалтуудаар тайлагнаж, нотлох баримтыг хавсаргаж байх,
 - Гэрээний хэрэгжилтийг гэрээ байгуулсан талууд хамтран дүгнэсэн дүгнэлтийн хамт гэрээний хэрэгжилтийн тайланг ХШҮ хийлгэхээр ирүүлж байх,
2. БСАДСМЗОД-ийн “Сургалт эрхлэгч байгууллага”-ын мөрдөх заалтуудыг хэрэгжүүлэн ажиллахад:
 - Дүрмийн хэрэгжилт хангалтгүй болон хэрэгжүүлээгүй, үнэлгээнээс хассан гэж үнэлэгдсэн 3.6.2, 3.6.3, 3.6.4, 3.6.7, 4.6 заалтуудын хэрэгжилтийг хангуулахад анхаарч ажиллах,
 - Шалгалтын тест боловсруулах, суралцагчдын мэдээллийг зохион байгуулагч байгууллагад хүргүүлэхэд анхаарч салбарын нэгдсэн мэдээллийн санг хөтлөх, мэргэжилтэй боловсон хүчний нөөцийн бүртгэлийг тасралтгүй гүйцэтгэхэд хамтран ажиллах,

- Зөвлөлд өөрийн төлөөлөл гишүүнтэй төрийн бус байгууллагын хувьд зохион байгуулагч байгууллагатай хамтран ажиллахад анхаарч, сургалттай холбоотой аливаа асуудал, гүйцэтгэсэн ажлын тайланг Зохион байгуулагч байгууллагаар дамжуулан зөвлөлд тайлагнаж гарсан зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах,
- 3. Сургалтын хөтөлбөр, сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах, тайлагнахад:
 - БСАДСМЗОД-д зааснаар зохион байгуулагч байгууллагаар дамжуулан сургалтын хөтөлбөр, сургалтын төлөвлөгөөний төслийг дүрэмд заасан хугацаанд зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулах,
 - Зохион байгуулагч байгууллагын шалгалт зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлж байгаа “МБИХ” болон түншлэгч төрийн бус байгууллагуудтай хамтран бий болгосон “сургалт, шалгалтын цахим систем”-ийг хөгжүүлэх, түүгээр дамжуулан сургалт, шалгалтын үйл ажиллагааг зохион байгуулахад өөрийн эрхэлж байгаа сургалтын хүрээгээр хамтран ажиллах,
 - Салбарын архитектор, эдийн засагч, инженерүүдэд хүртээмжтэй байдлаар сургалтын талаарх мэдээ мэдээллийг ил тод, нээлттэй хүргэхэд анхаарч олон төрлийн цахим системийг ашиглах,
 - Сургалтын хөтөлбөр, сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнахдаа сургалт зохион байгуулахаар зарласан зар, хөтөлбөр, хамрагсдыг сургалтын үе шат бүрээр нь тоо баримттай гаргаж байх.
 - Хөтөлбөрийн дагуу зохион байгуулсан сургалтын материалыг нотлох баримтад хавсаргах
- 4. Гэрээний хэрэгжилтийг тайлагнахдаа Засгийн газрын 2025 оны 183 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд хяналт тавих нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх боломжтой байдлаар тайлагнаж байх санал, Зөвлөмжийг гаргаж байна.

Тайланг хянасан:

СХШҮДАГ-ын даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч

Б.Найрамдал

Боловсруулсан:

СХШҮДАГ-ын шинжээч

Б.Одбаатар